



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/222

Булган сум

Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн  
өвс, тэжээлийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт цасан шуурга шуурсны улмаас зарим сумдад мал аж ахуйн хаваржилтад хүндрэл үүсэж байгаа талаар сумын Засаг дарга нараас гаргасан санал, хүсэлт болон аймгийн аюулгүй нөөцөд 2022-2023 онд бэлтгэсэн өвс, тэжээл хадгалалтын шаардлага хангахгүй (агуулах сав байхгүй ил задгай хураасан) байгаагаас чанар байдал алдагдаж болзошгүй зэрэг нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн аюулгүйн нөөцөд хадгалагдаж байгаа 1600 боодол өвсийг 1 боодлыг 2000 (хоёр мянга) төгрөгөөр, 30 тонн тэжээлийг 1 килограммыг нь 300 (гурван зуу) төгрөгөөр тооцож, хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу тус тус худалдан борлуулсугай.

2. Худалдан борлуулах өвс, тэжээлийг сумдаас ирүүлсэн саналыг үндэслэн хуваарилж, орлогыг аймгийн "Мал хамгаалах сан"-гийн 100040051410 тоот дансанд төвлөрүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Д.Алтаншагай), Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, (хурандаа Ш.Баасандорж) нарт тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



2023 оны 04 сарын 06 өдөр бүр. Дугаар А/2023/Захирамж

6323010196

Аймгийн Засаг даргын 2023. оны  
04 дүгээр сарын 09-ны өдрийн А/22 дугаар  
захирамжийн хавсралт



АЮУЛГҮЙН НӨӨЦИЙН ӨВС, ТЭЖЭЭЛ ТАРААХ ХУВААРЬ

Д/д	Нэр төрөл	Сумын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Өвс	Орхон	800 боодол	2000	1,600,000
2		Хишиг-Өндөр	300 боодол		600,000
3		Булган	200 боодол		400,000
4		Сайхан	300 боодол		600,000
<b>Бүгд</b>			<b>1600 боодол</b>		<b>3,200,000</b>
5	Тэжээл	Орхон	6 тн	300,000	1,800,000
6		Могод	5 тн		1,500,000
7		Гурванбулаг	10 тн		3,000,000
8		Булган	4 тн		1,200,000
9		Дашинчилэн	5 тн		1,500,000
<b>Бүгд</b>			<b>30 тн</b>		<b>9,000,000</b>